



МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 46.10 дугаар зүйл, Мандал Даатгал ХК-ийн Дүрмийн 8.14 дүгээр зүйл болон компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 сарын 18-ны өдрийн хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

- “Мандал Даатгал” ХК нь 2024 онд 8,3 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан бөгөөд 2024 оны татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 8,10 (найман төгрөг арван мөнгө) төгрөг буюу нийт 5,056,842,960.00 (таван тэрбум тавин зургаан сая найман зуун дөчин хоёр мянга есөн зуун жар) төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсүгэй.
- Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
- Энэхүү тогтоолын дагуу ногдол ашгийг 2025 оны 04 сарын 30-ны өдрийн дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд шилжүүлж олгохыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшинд даалгасугай.
- Энэхүү тогтоолын дагуу ногдол ашиг хуваарилсны дараа Компани нь төлбөрийн чадвартай байх бөгөөд Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа болохыг дурдсугай.
- Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн энэхүү шийдвэрийг 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшинд даалгасугай.

Энэхүү шийдвэрийг 2025 оны 02 сарын 18-ны өдөр бичгээр үйлдсэнийг гэрчлэн Компанийн тухай хуулийн 80.2 болон Компанийн дүрмийн 8.16 дах заалтыг тус тус үндэслэн ТУЗ-ийн дарга гарын үсэг зурав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ